

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Номгон сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ӨМА-2026/012/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2026 он</p> | <p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: П.Санчиргарав Утас: 70533552 Цахим хаяг: Sanchirgaravp@audit.gov.mn</p> |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539 | Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: omnugovi@audit.gov.mn

2026.03.25 № 843

танай _____ -ны № _____ -г

НОМГОН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БУЯНХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Номгон сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсвийн орлогыг 778,320.1 мянган төгрөг байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,176,856.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн 264,237.0 мянган төгрөгийн авто замын зураг төсвийн ажлыг бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний дагуу 27 бүлгийн хүрээнд 202 арга хэмжээг хэрэгжүүлэн 90.4 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайлант өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4626250833

812 Санхүүгийн 260811

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2025 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|-------|---|----------------|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 2,070,814.4 | 3,478,429.9 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 1,607,000.4 | 2,026,087.9 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 240,650.6 | 200,067.4 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 223,163.3 | 872,825.2 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 25,016,540.4 | 24,424,232.1 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 25,016,540.4 | 24,424,232.1 |
| 39200 | Биет хөрөнгө | | 24,792,733.0 | 24,200,862.1 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 223,807.4 | 223,370.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 27,087,354.8 | 27,902,662.0 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 8,628,466.8 | 8,286,708.4 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 258,780.4 | 352,604.2 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 255,781.6 | 349,605.4 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 18а, 18б | 2,998.8 | 2,998.8 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 8,369,686.5 | 7,934,104.2 |
| 42200 | Урт хугацаат зээл | 20а, 20б | 8,369,686.5 | 7,934,104.2 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 18,458,887.9 | 19,615,953.6 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 18,458,887.9 | 19,615,953.6 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 1,312,139.1 | 1,312,139.1 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 16,574,171.6 | 17,731,237.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 572,577.2 | 572,577.2 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 27,087,354.8 | 27,902,662.0 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 14,071,137.80 | 8,250,329.30 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,015,276.10 | 1,195,662.10 |
| 110 | Орлогын албан татвар | 580,919.50 | 709,763.80 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 600,919.50 | 739,134.30 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (20,000.00) | (29,370.50) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 134,758.10 | 151,464.70 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 299,598.50 | 334,433.60 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,817,498.00 | 7,054,667.20 |
| 120 | Тусламжийн орлого | - | 2,302,845.70 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 8,238,363.70 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 6,622,255.00 | 5,195,830.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,622,255.00 | 5,195,830.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,540,145.20 | 5,059,093.90 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,191,012.60 | 1,568,831.70 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 149,514.70 | 198,005.60 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 789,861.10 | 679,746.90 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 122,395.40 | 193,660.40 |
| | Нормативт зардал | 56,234.80 | 56,068.30 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 74,720.50 | 140,743.60 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 19,568.00 | 14,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 281,485.10 | 245,939.30 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,855,352.90 | 1,961,698.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 82,109.70 | 136,736.40 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 7,448,882.80 | 3,054,498.90 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,839,509.00 | 1,897,433.30 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 5,609,373.80 | 1,157,065.70 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

| Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---------------------------------------|--|------------------------|
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 9,763,032.30 | 12,849,514.20 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 9,763,032.30 | 12,849,514.20 |
| Тайлант үеийн үр дүн | 3,086,481.90 | 5,609,373.80 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 12,849,514.20 | 18,458,887.90 |
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 12,849,514.20 | 18,458,887.90 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 12,849,514.20 | 18,458,887.90 |
| Тайлант үеийн үр дүн | 5,609,373.80 | 1,157,065.70 |
| 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 18,458,887.90 | 19,615,953.60 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 13,030,766.36 | 10,951,989.63 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,015,276.09 | 1,135,390.63 |
| 110 | Орлогын албан татвар | 580,919.52 | 644,357.78 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 600,919.52 | 644,357.78 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (20,000.00) | - |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 134,758.10 | 151,464.74 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 299,598.47 | 339,568.10 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 27,095.81 | 48,377.79 |
| 1181 | Газрын төлбөр | 165,932.19 | 126,771.06 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 106,570.48 | 164,419.26 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,036,510.00 | 9,816,599.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,036,510.00 | 1,171,268.15 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,978,980.27 | 6,444,554.36 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 7,810,728.98 | 10,248,664.94 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 7,810,728.98 | 10,248,664.94 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,099,939.48 | 1,460,513.68 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,099,939.48 | 1,460,513.68 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 188,075.96 | 269,452.10 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 801,672.69 | 801,672.70 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 251,872.20 | 251,872.20 |
| 2105 | Нормативд зардал | - | 1,420.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 81,188.45 | 81,188.40 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 19,568.00 | 14,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 302,971.23 | 334,055.13 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 297,258.50 | 622,653.26 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,721,673.31 | 6,035,961.23 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 5,220,037.38 | 703,324.69 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | (4,442,973.68) | (284,237.93) |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,442,973.68 | 284,237.93 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,442,973.68 | 284,237.93 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (4,442,973.68) | (284,237.93) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 777,063.70 | 419,086.76 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 829,936.73 | 1,607,000.43 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,607,000.43 | 2,026,087.19 |

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:1 Хөтөлбөрөөс 8.5 сая төгрөгийн сургалтын дэмжлэгийг шалгуур үзүүлэлтгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-д

"Гадаадын болон дотоодын мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгоно", 11.5 "Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:2 Эрүүл Номгон-чууд хөтөлбөрт хөрөнгө оруулалтын шинж чанартай 4.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:3 Малчдыг дэмжих аян дэд хөтөлбөрт хөрөнгө оруулалтын шинж чанартай 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:4 Хөтөлбөрийн зардлаас 2.0 сая төгрөгөөр спортын тэмцээн уралдаан зохион байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:5 "Эко Номгон сум хөтөлбөр"-т хөрөнгө оруулалтын шинж чанартай ажилд 13.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:6 Нөөц сангаас сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн ажилтанд 3.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2-д "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно", 6.5-д "Нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус тус хяналт тавина", 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:7 Соёлын ажилтны өдрүүд арга хэмжээ зохион байгуулахад 10.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт:1 Сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 5/02 дугаар "Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор 430.0 сая төгрөгийн 5 хөтөлбөр хэрэгжүүлэхээр батлуулсан нь Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй хөтөлбөртэй уялдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аймгийн ИТХ-аар баталсан хөтөлбөрүүдтэй уялдуулж, төлөвлөхийг зөвлөж байна

Илрүүлэлт:2 Сумын төвийн хог хаягдлын зардлыг Тамгын газрын төсөвт тусган батлуулж, олгохдоо гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын ангиллыг үнэн зөв тодорхойлж, үндэслэлтэй төлөвлөхийг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 02-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл асуудал

/мянган төгрөгөөр/

| Алдаа зөрчлийн утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|-----------|---------------|-----|-----------------|----------|---------|-----------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сумын төвийн хог хаягдлын зардлыг Тамгын газрын төсөвт тусган батлуулж, олгохдоо гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй | 1 | 140,556.2 | | | | | 1 | 140,556.2 | | | | |
| "Эко Номгон сум хөтөлбөр"-т хөрөнгө оруулалтын шинж чанартай ажилд 13,000.0 мянган төгрөг зарцуулсан | 1 | 13,000.0 | | | 1 | 13,000.0 | | | | | | |
| Соёлын ажилтны өдрүүд арга хэмжээ зохион байгуулахад 10,000.0 мянган төгрөг зарцуулсан | 1 | 10,000.0 | | | 1 | 10,000.0 | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаагүй | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 5/02 дугаар "Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор 430.0 сая төгрөгийн 5 хөтөлбөр хэрэгжүүлэхээр батлуулсан нь Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй хөтөлбөртэй уялдаагүй | 1 | 430,000.0 | | | | | 1 | 430,000.0 | | | | |
| Эрүүл Номгон-чууд хөтөлбөрт хөрөнгө оруулалтын шинж чанартай 4,898.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан | 1 | 4,989.5 | | | 1 | 4,989.5 | | | | | | |
| Хөтөлбөрийн зардлаас 2,000.0 төгрөгөөр спортын тэмцээн уралдаан зохион байгуулсан | 1 | 2,000.0 | | | 1 | 2,000.0 | | | | | | |
| Малчдыг дэмжих аян дэд хөтөлбөрт хөрөнгө оруулалтын шинж чанартай 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан | 1 | 20,000.0 | | | 1 | 20,000.0 | | | | | | |
| Хөтөлбөрөөс 8,470.0 мянган төгрөгийн сургалтын дэмжлэгийг шалгуур үзүүлэлтгүй олгосон | 1 | 8,470.0 | | | 1 | 8,470.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|-----------|------------------|--|--|-----------|-----------------|----------|------------------|---|---|---|---|
| Нөөц сангаас 4,000,000 төгрөгөөр шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулсан | 1 | 4,000.0 | | | 1 | 4,000.0 | | | | | | |
| Нөөц сангаас сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн ажилтанд 3,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон | 1 | 3,000.0 | | | 1 | 3,000.0 | | | | | | |
| Татвар төлөгчдийн өдрийн арга хэмжээний хүрээнд 2,947.5 мянган төгрөгөөр дартс, гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан | 1 | 2,947.0 | | | 1 | 2,947.0 | | | | | | |
| Дүн | 12 | 638,872.2 | | | 10 | 68,316.0 | 2 | 570,556.2 | - | - | - | - |